



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/284

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх хэсэг, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Жаргалант сумын Алагтолгой баг 1 дүгээр гудамжны 42 тоотод байрлах, гэр, орон сууцны хашааны зориулалттай Цагааны Нэргүй /ПЭ61013125/-ийн эзэмшлийн 1692 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Нармандахын Алтанзаяа /ПЭ83110110/-д шилжүүлж, хаягийг Баянбулаг 4 дүгээр гудамжны 430 тоот болгон 6 жилийн хугацаагаар,

2. Жаргалант сумын Цамбагарав багийн 9 дүгээр гудамжны 16 тоотод байрлах эрүүл мэндийн байгууллагын зориулалттай Самдангийн Сүрэнхүү /ЧР56031208/-ийн эзэмшлийн 781 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Найдангийн Сонинцэцэг /ПЭ61111609/-д хаягийг Ану хатан 2 дүгээр гудамжны 213 тоот болгон 6 жилийн хугацаагаар тус тус шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

3. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлэн авч, газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлэхийг дээрх иргэдэд үүрэг болгосугай.

4. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэдтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02-Zah-A/284-Bo